

Бага боловсролын I-V ангийн сургалтын хэрэглэгдэхүүний төрөл, жагсаалт шаардлага

*1.5 Бага боловсролын Хүн ба нийгэм сургалтын хэрэглэгдэхүүний төрөл, жагсаалт, шаардлага*

*Хүснэгт 1. Бага боловсролын Хүн ба нийгмийн сургалтын хэрэглэгдэхүүний товчоо (нэр, төрлөөр)*

№	Хэрэглэгдэхүүний төрөл	Нийтлэг	Анги /тоо		Бүгд
			IV анги	V анги	
1	Хэвлэмэл материал	3	2	1	6
2	Зурагт үзүүлэн	6	-	3	10
3	Дижитал үзүүлэн	3	-	3	

“ Хүн ба нийгэм “ хичээл/ судлагдахууны онцлогтой сургалтын хэрэглэгдэхүүний шаардлага

*Хэвлэмэл үзүүлэнд тавих ерөнхий шаардлага:*

\*Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага (MNS 5418:2008)-ыг хангасан байна.

\*Сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон үг хэллэг бичвэртэй байна.

\*Санамж бичвэрүүд, тулгуур дохиогоор илэрхийлсэн санамжууд байна.

\*Дэлгэрэнгүй, тодорхой тайлбартай байна.

\*Шинжлэх ухаан, ёс суртахуун, сэтгэл, мэдрэмжийн үндэстэй, баталгаатай, сүүлийн үеийн эх сурвалжид тулгуурласан байна.

\*Монгол үндэстний өв, уламжлал, ёс заншил, түүх, соёл, хэл, сэтгэлгээний язгуур онцлог, үндэсний ижилсэлд тулгуурласан байна.

\*Мэдлэг, ойлголтыг амьдрал ахуй, бодит практиктай нягт холбосон шийдэлтэй байх

\*Суралцагчийн ёс суртахууны үнэт чанар, төлөвшил, хүмүүжил, хөгжилд бодитой дэмжлэг үзүүлэхүйц, тайлбар бүхий зураг, кейс, тохиолдол, баримт байна.

\*Суралцахуй, багшлахуй болон хичээл, хичээлээс гадуурх үйл ажиллагааг дэмжихүйц, тэдгээрийн нэгдлийг хангасан байна.

\*Хэл найруулга нь тодорхой, ойлгомжтой, ёс суртахууны үнэт чанарыг нээн харуулахуйц, утга агуулга, томъёолол, бичлэг, үг хэллэгийн болон зөв бичих дүрмийн алдаагүй бичигдсэн байна.

\*Зохиогчийн эрхийн зөрчилгүй байна.

*Зурагт үзүүлэнд тавих шаардлага:*

\*Хэвлэмэл бүтээгдэхүүнд тавигдах ерөнхий шаардлага /Зурагт хуудас/ MNS 5553-3:2005, 5553-4:2005 стандарт, Хэвлэлийн бүтээгдэхүүний чанарт тавих шаардлага MNS 6789:2019 стандартын дагуу хийгдэнэ.

\*Зурагт хуудасны зориулалт, хэрэглээнээс хамаарч хэмжээг тодорхойлно. Хэрэв хананд байрлуулах бол хүүхдэд харагдах байдлыг тооцохыг анхаарна.

\*Хүн ба орчин хичээлийн “Ургийн бичиг” хөтлөх загвар тэмдэг тэмдэглэгээ бүхий зурагт хуудсыг хэрэглэж болно.

\*Зураг, дүрслэл, илэрхийлэл нь гоо зүй, техник, технологийн онцлог шаардлагыг хангасан байна.

\*Монгол орны газрын зураг /аймаг, сум, суурин газрыг тэмдэглэсэн, түүх соёлын өв, дархан цаазат газар, байгалийн цогцолбор газруудыг тэмдэглэсэн/ (хананд өлгөж хэрэглэнэ.)

\*Зургаар, ойлгомжтой илэрхийлсэн санамжууд, бичвэрүүд байна.

\*Сурагчдад ойлгомжтой тэмдэг тэмдэглэгээтэй, хэмжээ нь А2-оос багагүй байна.

\*Өнгө будгийн ялгарал сайтай, тэмдэг тэмдэглэгээ нь тод, ойлгомжтой, уул нуруу, гол мөрөн, нуур, аймаг хот, сум, дархан цаазат газруудын нэрийг дэлгэрэнгүй бичсэн, хэмжээ нь А2-оос багагүй байна.

*Дижитал үзүүлэнд тавих шаардлага:*

\*Сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон байх Уншигч, өгүүлэгч, тайлбарлагчийн яриа нь тод чанга, ойлгомжтой, дуу, дүрсний шаардлагыг хангасан цахим үзүүлэн байна.

\*Нягтрал сайтай, дуу дүрсний алдаагүй байна.

*Хүснэгт 2. Бага боловсролын Хүн ба нийгмийн нийтлэг хэрэглэх сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт, шаардлага, тоо хэмжээ*

№	Хэрэглэгдэхүүний нэр	Хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага		Тоо хэмжээ (анги, танхим, кабинет, лабораторид байх)
		Хэрэглэгдэхүүний агуулга	Шаардлага /хэмжээ, холбогдох стандарт, бусад/	
<b>Хэвлэмэл материал</b>				
1	Монгол орны түүх соёлын дурсгалт газруудын лавлах, танилцуулга бүхий зурагт ном	<ul style="list-style-type: none"> <li>Монгол орны дархан цаазат болон байгалийн үзэсгэлэнт цогцолбор газрууд</li> <li>Эртний түүх дурсгалын хөшөө, туурь, балгас, олдворын фото зураг бүхий атлас ном /Тухайн орон нутгийн тухай бичигдсэн байж болно/</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Шинжлэх ухааны үндэстэй, алдаагүй, тухайн орон нутгийн соёлын өвийг харуулсан, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөж хэвлэгдсэн ном байна/</li> </ul>	Ангид-1, эсвэл сургуулийн номын санд 2-3 байх
2	“Сургамжит өгүүлэгүүд”	Өнөөгийн нийгмийн амьдралтай холбоотой бодит кейс, жишээнүүд бүхий сургамжтай, санаа авах өгүүлэгүүд, өгүүлэгийн түүвэр зохиол	Хэвлэгдэж гарсан “Сургамжит өгүүлэгүүд- 8 цуврал бүхий ном /Бага насны хүүхдийн сэтгэхүйд тохирсон, уншихад ойлгомжтой, үг үсгийн алдаагүй, хэвлэсэн ном байна/	Ангид-1, эсвэл сургуулийн номын санд 2-3 байх
3	Монголын хөрш улсуудын тухай танилцуулга, зураг бүхий ном	Хөрш 2 орны онцлог, нийгэм, соёлын талаар харуулсан фото зургууд бүхий тайлбартай лавлах ном, гарын авлага	Сурагчдын сонирхлыг татахуйц,нас сэтгэхүйн онцлогт тохирсон үг хэллэгтэй, хөрш 2 орны онцлог, соёлын талаар харуулсан фото зургууд бүхий тайлбартай, шинжлэх ухааны үндэслэлтэй ном байна/	Сургуулийн номын санд 2-3 байх

Зурагт үзүүлэн				
1	Монгол орны газрын зураг -1 /засаг захиргааны/	Монгол орны газрын зураг /Засаг захиргааны/	Монгол орны газар зүйн зураг, аймаг, хот, сумдыг хараад ойлгохуйц 1. Самбарын зураг. Масштаб: 1:2 500 000 2. Дасгалын ширээний зураг байна. Цаасны хэмжээ А3, Масштаб: 1:75 000 000	Хананд ангид – 1 ширхэг Дасгалын зураг Хоёр хүүхдийн дунд 1 ширхэг
2	Монгол орны газрын зураг /угсаатны зүйн/	Монгол орны аль аймгуудын нутгаар ямар үндэстэн ястан амьдардаг, эрхэлдэг хөдөлмөр, аж ахуй, уламжлалт ёс заншлыг нь харуулсан газрын зураг	Монгол орны тухайн орон нутгийн /газрын гадаргыг дүрсэлсэн байж болно/ 1. Газрын зураг. Масштаб: 1:2 500 000 /хэмжээтэй/ 2. Дасгалын ширээний зураг байна. Цаасны хэмжээ А3, Масштаб: 1:75 000 000	Хананд ангид – 1 ширхэг  Дасгалын зураг Хоёр хүүхдийн дунд 1 ширхэг
3	Өөрийн орон нутгийн засаг захиргааны /нэгжийн/ газрын зураг	Тухайн орон нутгийн онцлогийг харуулсан засаг захиргааны газрын зураг	Орон нутгийн онцлогтой (ашигт малтмал, ургамал, амьтан, газар тариалан гэх мэт) газрын зураг, аймаг, сум, дүүргийн зураг байж болно. 1. Дасгалын ширээний зураг байна. Цаасны хэмжээ А3, Масштаб: 1:75 000 000 2. Хананы зураг. Масштаб: 1:2 500 000	Хананд ангид – 1 ширхэг  Дасгалын зураг Хоёр хүүхдийн дунд 1 ширхэг
4	Үүрэг, хариуцлага, аюулгүй байдал сэдэвт зурагт үзүүлэн /багц /	”Хувь хүний үүрэг хариуцлага”сэдэвт -Үүрэг, амлалт хариуцлагыг харуулсан үзүүлэн-1ш /хананд/ -Үүрэг амлалтаа эс биелүүлдэг сурагчийн үзэл бодол, хор уршгийг харуулсан  -Сургуулийн гадна, болон дотор орчинд аюулгүй байдлыг хангах хамгаалах, урьдчилан сэргийлэх зөвлөмж, санамж бүхий зургууд 4-5 /  -Цахим аюулгүй байдлыг хангах зурган зөвлөмж	Хананд өлгөх үзүүлэнгүүд том, 50-иад хүүхэд хараад ялгахаар, сольж өлгөхөд тохиромжтой 100x150 см,түүнээс багагүй хэмжээтэй байна. Зөвлөмж зургууд нь А3 хэмжээтэй, дулаан өнгө будгийн ялгарал сайтай, бага насны хүүхдийн онцлогт тохирсон ойлгомжтой, түлхүүр цөөн үгсээр гол санааг нь илэрхийлсэн, сольж өлгөх болон хадгалахад хялбар нугарч, урагдахааргүй байна.	Ангид- 1

5	<p>”Хувь хүн” болон “Нийгмийн/ хамтын амьдрал” сэдэвт зурагт багц үзүүлэн</p>	<p>Дараах агуулгын хүрээнд байна -Хүмүүсийн эерэг сөрөг харилцаа хандлагыг тодорхойлж бичих дэс дараатай үйл явдал бүхий зурган эхүүд /Жишээ нь: Замын хөдөлгөөнд зөв болон буруу оролцож байгаа 2 сурагчийг харуулсан үйл явдал бүхий, г.м зөв буруу үйлдлийн талаар</p> <p>-Харилцааны эерэг,сөрөг нөлөөг илэрхийлсэн зургууд нүүр царай болон биеийн үйлдлээр хийж буй хандлагаа илэрхийлж байгаа зургууд – инээсэн, уурласан, зальжин, дээрэлхсэн, үл тоосон, бахархан хүндэтгэсэн, айсан гэх мэт сэтгэл хөдлөлийн байдлыг илтгэсэн – 8 ш /</p>	<p>Дэс дараалалтай үйл явдал бүхий зурагт үзүүлэнгүүд нь А2 байна. -Хүний хандлага, нүүрний хувирлыг харуулах үзүүлэнгүүд нь А3 хэмжээтэй байх Хананд өлгөх үзүүлэнгүүд том, 50-иад хүүхэд хараад ялгахаар, сольж өлгөхөд тохиромжтой 100х150 см,түүнээс багагүй хэмжээтэй байна. -Зөвлөмж зургууд нь А3 хэмжээтэй, өнгө будгийн ялгарал сайтай, зураг нь бага насны хүүхдүүдэд ойлгомжтой, түлхүүр цөөн үгсээр гол санааг нь илэрхийлсэн, сольж өлгөх болон хадгалахад хялбар нугарч, урагдахааргүй байна.</p>	Ангид-1
6	<p>“Нутгийн хүмүүсийн амьдрал” сэдэвт зурагт багц үзүүлэн</p>	<p>Нутгийн ёс заншилтай холбогдолтой зураг, домог, хууч, түүхэн дурсгалт газар, бахархалт хүмүүсийн тухай зурагт үзүүлэн</p>	<p>1. Нутгийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагааг харуулсан бүдүүвч – 1ш 2. Угсаатны зүйн зураг, угсаатан ястнуудын үндэсний хувцастай зургууд – 15ш /Бүх үзүүлэнгүүд А2 хэмжээтэй байна /</p>	Ангид-1
Дижитал үзүүлэн /сонсох, харах ...				
1	Баримтат кино – 1	Нутаг нутгийн газар зүйн онцлог, хүмүүсийн эрхлэх хөдөлмөр, ёс заншлын ялгааг харуулсан сэдэв бүхий кино 20 минутаас хэтрэхгүй бичлэг		Ангид-1
2	Бичлэг	Аюул, осол, газар хөдлөлт, гал түймэр, үер усны хор уршгийг харуулсан бичлэг, тэдгээрээс хамгаалах зөвлөмж бичлэгүүд		Ангид-1

*Хүснэгт 3. Хүн ба нийгэм (IV анги)-ийн сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт,  
шаардлага, тоо хэмжээ*

№	Хэрэглэгдэхүүний нэр	Хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага		Тоо хэмжээ (анги, танхим, кабинет, лабораторид байх)
		Хэрэглэгдэхүүний агуулга	Шаардлага /хэмжээ, холбогдох стандарт, бусад/	
<b>Хэвлэмэл материал</b>				
1	Нутаг нутгийн ёс заншил, уул устай холбогдолтой домог, хууч ярианы цуглуулга бүхий ном зохиол	Өөрийн төрсөн нутаг болон Монгол орны уул нурууд, гол мөрөнгийн тухай домгийн эмхтгэл, фото зураг бүхий атлас ном байх	Хүүхдэд зориулагдсан үг хэллэгтэй, шинжлэх ухааны үндэстэй, олон нийтийн хэртээл болж хэвлэгдсэн ном байна.	Анги -1, эсвэл сургуулийн номын санд 2-3 байх
2	Тухайн орон нутгийн /нийслэлийн / алдар цуутай хүмүүсийн тухай лавлах ном	Тухай аймаг, нутгаас /нийслэлээс/ төрөн гарсан алдар цуутай хүмүүсийн фото зураг, алдаршиж нэрээ мөнхөлсөн ажил үйлсийн тухай бичвэр бүхий намтар ном		Ангид-1, эсвэл сургуулийн номын санд 2-3 байх

*Хүснэгт 4. Хүн ба нийгэм (V анги)-ний сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт,  
шаардлага, тоо хэмжээ*

№	Хэрэглэгдэхүүний нэр	Хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага		Тоо хэмжээ (анги, танхим, кабинет, лабораторид байх)
		Хэрэглэгдэхүүний агуулга	Шаардлага /хэмжээ, холбогдох стандарт, бусад/	
<b>Хэвлэмэл материал</b>				
1	“Чингис хаан” хүүхдийн комик, цуврал ном	Чингис хаан” – ы бага нас, түүхэн замналын тухай хүүхдэд ойлгогдохуйц үг хэллэгтэй, сонирхлыг татахуйц, үйл явдал бүхий зураг дүрслэлтэй унших ном зохиолууд	“Чингис хаан” хүүхдийн комик ном нь хүүхдэд зориулагдсан үг хэллэгтэй, сонирхлыг татахуйц, үйл явдал бүхий зураг дүрслэлтэй уншихад хялбар хэвлэсэн ном байна.	Ангид-1, эсвэл сургуулийн номын санд 2-3 байх
<b>Зурагт үзүүлэн</b>				
1	”Миний эх орон” сэдэвт зурагт үзүүлэнгийн багц /	. Монгол төрийн сүлд, - Монгол төрийн туг, -Монгол төрийн далбаа, -Төрийн тамга -Төрийн дуулал	Төрийн сүлд, төрийн туг, түүний бэлэгдэл бүхий тайлбартай багц зурагт хуудас нь зөв утгийн алдаагүй байх А4-А3 хэмжээтэй байх	Сурагч бүрт -1, эсвэл 2 сурагчийн дунд 1 байх
2	Монгол бахархал” сэдэвт 25 зураг бүхий үзүүлэнгийн багц/	Дараах агуулгын хүрээнд зурагт үзүүлэн бэлдсэн байна. -. Модунь Шаньюгийн хөрөг зураг, тайлбар	Зурагт хуудсуудын зураг тайлбар нь зөв, алдаагүй бичигдсэн, шинжлэх ухааны үндэслэлтэй эх сурвалжтай байх,	Ангид-1, эсвэл сургуулийн номын санд 2-3 байх

		<ul style="list-style-type: none"> <li>- Чингис хаан, түүний 9 өрлөгийн хөрөг</li> <li>- Өгөдэй,Хубилайхаан</li> <li>-Мандухай цэцэн хатан</li> <li>-Галдан бошигт</li> <li>- Чингүжав,Амарсанаа</li> <li>- VIII Богд Живзундамба хутагт, Чин ван</li> <li>М.Ханддорж</li> <li>- С.Данзан, Д.Бодоо,</li> <li>Д.Сүхбаатар нар</li> <li>- Дэлхийн II дайны хор уршиг, үр дагавар</li> </ul>	хүүхдэд ойлгмжтой үг хэллэгтэй, хэмжээ А3-А2 /люминатордсан, сурагч бүр дамжуулж хэрэглэхдээ цэвэрлэж болохоор гялгар бүрэлтэй байна/	
3	Газрын зураг	<p>Дараах агуулга бүхий газрын зураг байна</p> <ul style="list-style-type: none"> <li>- Их Монгол улсын тухайн үеийн газрын зураг нь Одоогийн Монгол улс тэр үеийн улсын дотор нь багтсанг харуулсан, одоогийн ямар улс орнууд тэр үед Монголчуудын захиргаанд байсныг харуулсан</li> </ul>	А2 хэмжээтэй, зөв, алдаагүй хийгдсэн тод харагдахуйц, хананд өлгөх зориулалттай байна.	Ангид-1
Дижитал үзүүлэн /сонсох, харах ...				
1	Баримтат кино – 1	Монгол улс НҮБ-д элссэн	Өгүүлэгч, болон яриа тод зөв ойлгомжтой 10 минутын бичлэг байна.	Ангид-1
2.	Баримтат кино – 2	<ul style="list-style-type: none"> <li>-“Монголчууд ХХзууны эхэнд”</li> <li>-VIII Богд Живзундамба хутагт, -Чин ван</li> <li>М.Ханддорж зэрэг түүхэн хүмүүсийн намтар, үйл ажиллагаанаас харуулсан дүрс бичлэг, киноны хэсэг</li> <li>-Аж үйлдвэр, газар тариалангийн хөгжлийн талаар, нийтээр бичигтэн болсон, номын сан, уран сайхны клуб, музей болон эмнэлэг, ахуйн соёлын үйлчилгээг харуулсан</li> <li>-Дэлхийн II дайны хор уршиг, үр дагавар</li> </ul>	Өгүүлэгч, болон яриа тод зөв ойлгомжтой 10-15 минутын бичлэг байна.	Ангид-1